



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 06 өдөр

Дугаар А/394

Хэрлэн сум

Багаж тоног төхөөрөмж худалдан
авахад хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.3, 32.1.10 дахь заалт, "Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөө"-ний 2.4-т заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүчтэй газар хөдлөлтөөс үүсэх хөрсний чичирхийллийн хэмжээг бичигч багажийг хүн амын төвлөрөл ихтэй зарим сумдад суурилуулах ажлыг зохион байгуулахад 19,500,000 (арван есөн сая таван зуун мянга) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Газар хөдлөлтөөс үүсэх хөрсний чичирхийллийн хэмжээг бичигч багажийг худалдан авах ажиллагааг зохион байгуулж бэлэн байдлыг хангуулан, ашиглалтын явцад хяналт тавьж ажиллахыг Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чингис хотын захирагч (М.Шүрэнцэцэг), Бор-Өндөр сумын Засаг дарга (Г.Адъяабилэг) нарт тус тус үүрэг болгосугай.

4. Дээрх ажилд шаардагдах хөрөнгийг аймгийн эрсдэлийг бууруулах сангаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2023 оны 07 дугаар сарын 06-ны захирамжийн нэгдүгээр хавсралт

1/394

ЗАРДЛЫН ТООЦОО

д/д	Сумын нэр	Нийт үнэ
1	Хэрлэн	9.750.000
2	Бор-Өндөр	9.750.000
	Дүн	19.500.000